



СКАЙМЕДИА КОРПОРАЦИ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А-21

Улаанбаатар хот

Сүлжээ хооронд харилцан холболт хийх  
гэрээний нөхцөлийг батлах тухай

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 33 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг хавсралтаар баталж, 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан нөхцөлийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү төлөвлөлтийн газрын захирал /Б.Болорчулуун/ болон Технологийн газрын захирал /Я.Батжаргал/-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэ нөхцөлийг компанийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээллэхийг Маркетингийн газрын захирал /Ж.Сарнай/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.АМАРЧИНГҮН



## СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөл” (цаашид “Нөхцөл” гэх)-ийг Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолоор баталсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Журам” гэх)-ыг үндэслэл болгон Сүлжээ хооронд харилцан холболт хийх үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.
- 1.2 Энэхүү нөхцөлөөр Скаймедиа корпораци ХХК (цаашид “Скаймедиа” гэх) болон Сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлт гаргагч (цаашид “Харилцаа холбооны үйлчлэгч” гэх) нарын (хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээтэй холбоотой технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага, ашиглалт үйлчилгээ, зааглах цэгийн байршил, гэрээ байгуулах үйл ажиллагаа, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, орлого хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.3 Талууд сүлжээ хоорондын харилцан холболт хийх үйл ажиллагаандаа Зохицуулах хорооноос батлан гаргасан дараах баримт бичгийг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:
  - 1.3.1 Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам /2021 оны 33 тоот тогтоол/
  - 1.3.2 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага /2020 оны 23 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт/
  - 1.3.3 Харилцан холболтын орлого хуваарилах зарчмыг хянан батлах тухай /2011 оны 23 тоот тогтоол/
- 1.4 Скаймедиа нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий телефон ярианы үйлчилгээ эрхлэгчтэй Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ байгуулахдаа хууль, журам болон энэхүү нөхцөлд заасан хэм хэмжээг мөрдлөг болгоно.
- 1.5 Энэхүү нөхцөлд Скаймедиа нь шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах боломжтой бөгөөд үүнийг ил тод, нээлттэй мэдээлнэ.

### ХОЁР. НЭР ТОМЬЁО

- 2.1 “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөл” гэж “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.3 дахь хэсэгт заасан мэдээллийг агуулсан баримт бичгийг ойлгоно.
- 2.2 “Харилцаа холбооны үйлчлэгч” гэж Зохицуулах хорооноос харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үүрэн холбоо эсхүл суурин холбооны үйлчилгээ эрхлэхээр авсан иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.
- 2.3 “Телефон ярианы үйлчилгээ” гэж “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Телефон ярианы үйлчилгээнд)”-ын 1.3 дахь хэсэгт заасан үүрэн болон суурин холбооны бүх төрлийн телефон ярианы үйлчилгээг ойлгоно.
- 2.4 “Зааглах цэг” гэж Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь хэсэгт зааснаар үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг ойлгоно.

### ГУРАВ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ



- 3.1 Скаймедиа нь Сүлжээ хооронд харилцан холболт хийх Харилцаа холбооны үйлчлэгчдэд ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтална.
- 3.2 Скаймедиа нь Сүлжээ хооронд харилцан холболт хийхэд нээлттэй сүлжээний стандартыг хангах зарчмыг баримтална.
- 3.3 Талууд нь Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ байгуулах, орлого хуваарилах зарчим, төлбөрийн хэмжээг тогтоохдоо аливаа бизнесийн алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй.
- 3.4 Талууд нь өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас сүлжээ хооронд харилцан холболт хийсэн эсхүл сүлжээнд нь холбогдсон харилцаа холбооны үйлчлэгчид үүссэн хохирлыг буруутай Тал хариуцна.
- 3.5 Сүлжээ хооронд харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх нөхцөлд Журмын 2.11 дэх заалтыг баримтална.

#### ДӨРӨВ. СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТ, ГОРИМ, НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 4.1 Харилцаа холбооны үйлчлэгч нь харилцаа холбооны бусад сүлжээнд холбогдож харилцан холболт хийхэд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 22 дугаар зүйл болон Зохицуулах хорооноос баталсан холбогдох журмыг баримталж Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ байгуулна.
- 4.2 Харилцаа холбооны үйлчлэгчийн техник, төхөөрөмж нь үндэсний болон олон улсын стандартын шаардлагыг хангасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар баталгаажуулагдсан, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх бусад сүлжээтэй харилцан холбогдох техникийн нөхцөлийг бүрэн хангасан байна.
- 4.3 Харилцаа холбооны үйлчлэгч нь харилцаа холбооны үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн системтэй байх ба хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 6 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг байна.
- 4.4 Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн үйлчилгээний чанар, стандарт болон норматив шаардлагыг ханган ажиллах зорилгын хүрээнд техник, тоног төхөөрөмжид байнгын хэмжилт, тогтмол хяналт хийх хэмжүүрийн багаж, хэрэгсэл эсхүл програм хангамжаар хангагдсан байна.
- 4.5 Харилцаа холбооны үйлчлэгч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхтэй холбоотой техник, тоног төхөөрөмжийн угсралт болон кабель шугамын суурилуулалтыг хийж гүйцэтгэхдээ энэ талаар батлагдан гарсан Үндэсний стандарт, норматив баримт бичгийг мөрдөж ажиллах ба хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээнд ашиглагдахаар байгуулсан сүлжээний найдвартай ажиллагаа, инженер техникийн ажилтны аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан байна.
- 4.6 Харилцаа холбооны үйлчлэгч нь ярианы үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай үндэсний болон олон улсын стандартын шаардлагыг хангасан холболтын байгууламж (soft switch, gateway, router), төлбөр тооцооны систем (billing system), зай тэжээлийн төхөөрөмж болон тэдгээрийн хяналтын систем (network management system)-ийг ашиглана.
- 4.7 Харилцаа холбооны үйлчлэгч нь дараах шаардлагыг хангасан холболтын байгууламжтай байна. Үүнд:
  - 4.7.1 Ярианы болон бусад холбогдох протоколууд ба кодыг дэмжих, тэдгээрийн хувиргалт, шилжилтийг хийдэг байх;
  - 4.7.2 Ярианы төлбөрийг секундйн нарийвчлалтай тооцох боломжтой байх;
  - 4.7.3 Эцсийн хэрэглэгчийн яриаг эхлүүлэх болон төгсгөх;
  - 4.7.4 Бусад сүлжээтэй ITU-T G.703 стандартын дагуу E1 болон IP холбох шугамаар холбогдох;



- 4.7.5 Ярианы ачааллын мэдээллийг чиглэл тус бүрээр (орох, гарах, транзит), холбогдох нэгжээр (эрланг, минут) гаргах боломжтой байх.
- 4.8 Харилцаа холбооны үйлчлэгч нь хуурамч дуудлага, дугаараа өөрчилж залгасан дуудлага, спам мессеж, дуудлагыг (spoof call, sim box detection, long call alerting, traffic volume assurance, telemarketing, spam messaging) илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх техник, тоног төхөөрөмжийн боломжийг бүрдүүлэн байнгын хяналт хийж ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.9 Харилцаа холбооны үйлчлэгч нь орох дуудлагын хувьд Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ын E.164-ийн дагуу дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулдаг (CLI-Calling Line Identification) байна.
- 4.10 Энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй Харилцаа холбооны үйлчлэгчтэй сүлжээ хоорондын харилцан холболт хийхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд Журмын 3.2 дахь хэсэгт заасан хугацаанд, 3.3 дахь хэсэгт заасан тайлбарыг албан бичгээр мэдэгдэнэ.

#### ТАВ. ЗААГЛАХ ЦЭГ ТОГТООХ НӨХЦӨЛ

- 5.1 Сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.7 болон 22.3 дахь заалт болон Журмын нэгдүгээр хавсралтын 1.1 дэх хэсэгт зааснаар аль нэг Харилцаа холбооны үйлчлэгчийн сүлжээний эсхүл дамжуулах төхөөрөмжөөр тодорхойлно. Зааглах цэгийн байршлыг Зохицуулах хороо эцэслэн баталгаажуулна.
- 5.2 Скаймедиа нь өөрийн сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн Хавсралт 1-д заасан ба энэ талаар Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд нарийвчлан тусгана.
- 5.3 Талууд зөвхөн Зохицуулах хорооноос тогтоосон зааглах цэгт сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээг үзүүлнэ.
- 5.4 Зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 5.2 дахь хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоохоор бол Журмын 5.3 дахь хэсэгт зааснаар Харилцаа холбооны үйлчлэгч уг хүсэлтийг гаргасан тохиолдолд Скаймедиа нь хүсэлтийн дагуу техникийн нөхцөлийн боломж байгаа эсэхийг тодорхойлж, дүгнэлтийг Зохицуулах хороонд албан бичгээр ирүүлж, шийдвэрлүүлнэ. Харин Скаймедиа нь зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 5.2 дахь хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоох хүсэлтэй бол Зохицуулах хороонд үндэслэл, техникийн нөхцөлийн боломжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлж, шийдвэрлүүлнэ.
- 5.5 Харилцаа холбооны үйлчлэгч нь Харилцаа холбооны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу Скаймедиагийн сүлжээнд харилцан холболт хийх зааглах цэг хүртэл шаардагдах хөрөнгө оруулалтыг хариуцна.
- 5.6 Талууд сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг бүрдүүлж, хангана.

#### ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1 Талууд сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээс хоёр тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.
- 6.2 Талууд нь Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээгээр үзүүлж буй үйлчилгээний чанарын шаардлагыг энэхүү нөхцөлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон зааглах цэгээс хоёр тийш тус тусын сүлжээний хүрээнд хангаж ажиллах үүрэг хүлээнэ.
- 6.3 Сүлжээ хооронд харилцан холболт хийх аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг Талууд урьдчилж харилцан тохиролцож гэрээнд тусгах ба үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.



## ДОЛОО. СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, ОРЛОГО ХУВААРИЛАЛТ

- 7.1 Сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний өртгийг тооцохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал, Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-аас гаргасан зөвлөмж, аргачлал, загвар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 7.2 Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан өртгөө нөхсөн байна.
- 7.3 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөлд тусгагдах сүлжээ хооронд харилцан холболт хийх төлбөр болон сүлжээ хоорондын харилцан холболтын орлого хуваарилах зарчмын тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, хэрэв тохиролцоонд хүрээгүй бол тус тусын саналыг үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 7.4 Зохицуулах хорооноос Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээ байгуулагдахаас өмнө болон гэрээний үргэлжлэх хугацааны дундуур сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, орлого хуваарилах зарчмын талаар хуульд заасан үндэслэл бүхий шийдвэр гаргасан тохиолдолд Талууд шийдвэрийг гэрээнд шууд тусган дагаж мөрдөх үүрэгтэй.
- 7.5 Талууд сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, орлого хуваарилах зарчмыг тогтоохдоо Зохицуулах хорооны 2011 оны 23 тоот “Харилцан холболтын орлого хуваарилах зарчмыг хянан батлах тухай” тогтоолыг баримтална.

## НАЙМ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- 8.1 Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтээ Журмын 3.1 дэх хэсэгт заасан хэлбэрээр гаргах бөгөөд уг хэлбэрээс бусад хэлбэрээр гаргасан аливаа хүсэлтийг шийдвэрлэхгүй.
- 8.2 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий телефон ярианы үйлчилгээ эрхлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтдээ дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:
  - 8.2.1 Сүлжээнд харилцан холбогдох зааглах цэгийн байршил;
  - 8.2.2 Холболт хийх гэж буй төхөөрөмжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
  - 8.2.3 Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим;
  - 8.2.4 Энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд тусгасан гэрээний нөхцөлийг хангах талаар бусад мэдээлэл.
- 8.3 Скаймедиа нь техникийн нөхцөл олгох боломжийг судлах зорилгоор энэхүү нөхцөлийн 8.2 дахь хэсэгт зааснаас гадна байгууллагын нууцад хамаарахгүй нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 8.4 Скаймедиа нь энэхүү нөхцөлийн 8.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд нийцэж байгаа эсэхийг судалж, Журмын 3.2 дахь хэсэгт заасан хэлбэр, хугацаанд хариу мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг техникийн нөхцөл гэж ойлгоно.
- 8.5 Скаймедиа нь Харилцаа холбооны үйлчлэгчид техникийн нөхцөл гаргах боломжгүй болсон тохиолдолд Журмын 3.3 дахь хэсэгт заасны дагуу хариу хүргүүлэх бөгөөд уг хариу тайлбартаа техникийн нөхцөл олгох боломжгүй үндэслэлийг тодорхой дурдана.
- 8.6 Скаймедиа нь энэхүү нөхцөлийн 8.1 дэх хэсэгт заасан хэлбэрээс өөр хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй талаар мэдэгдлийг бичгээр мэдэгдэнэ.



- 8.7 Скаймедиа нь Харилцаа холбооны үйлчлэгчдийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдөр, цаг, минутаар шүүж, түрүүлж ирснийг нь эхэнд шийдвэрлэх зарчим баримтална.
- 8.8 Харилцаа холбооны үйлчлэгчийн тусгай зөвшөөрөл нь хуульд заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд Скаймедиагаас олгогдсон техникийн нөхцөл хүчингүй болно.
- 8.9 Зохицуулах хорооны албан тушаалтан Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг хянахдаа энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйл “Сүлжээ хооронд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага”-ыг баталгаажуулах зорилгоор тоног төхөөрөмжийг газар дээр нь очиж, хяналт хийж болно.

#### ЕС. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 9.1 Скаймедиа нь Харилцаа холбооны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт зааснаар Харилцаа холбооны үйлчлэгчийг өөрийн сүлжээнд холбохдоо гэрээ байгуулна.
- 9.2 Энэхүү нөхцөлийн 9.1 дэх хэсэгт заасан гэрээг Сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулна. Сүлжээний ашиглалт, үйлчилгээг зохицуулахаар тусдаа гэрээ байгуулахгүй.
- 9.3 Скаймедиа нь Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйл “Сүлжээ хооронд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага”-ыг салшгүй хэсэг болгон тусгана.
- 9.4 Энэхүү нөхцөлийн 9.3 дахь хэсэгт заасан гэрээний салшгүй хэсэгт Харилцаа холбооны үйлчлэгчийн хүсэлтээр хууль болон Зохицуулах хорооноос баталсан журам, нөхцөл шаардлага, шийдвэрээр хязгаарласан асуудлаас бусад асуудлаар харилцан тохиролцож өөрчлөлт оруулах боломжтой. Бусад тохиолдолд энэхүү нөхцөлийн дөрөвдүгээр зүйлд зааснаас өөрөөр гэрээнд оруулахыг хориглоно.
- 9.5 Скаймедиа нь Харилцаа холбооны үйлчлэгчид олгосон техникийн нөхцөл энэхүү нөхцөлийн 8.8 дахь хэсэгт зааснаар хүчингүй болсон тохиолдолд сүлжээний харилцан холболтыг салгах арга хэмжээг авч, Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэнэ.
- 9.6 Скаймедиа болон Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээний ашиглалт, үйлчилгээг Журмын 7.2 дахь хэсэгт зааснаас өөрөөр хариуцах тохиолдолд гэрээндээ энэ талаар тодорхой тусгана.
- 9.7 Журмын 7.3 дахь хэсэгт заасан сүлжээ хооронд харилцан холболт хийх, түүнтэй холбоотой аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг Талууд харилцан тохиролцож гэрээнд тусгана.
- 9.8 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээг энэхүү нөхцөлийн Хавсралт 2-т заасан загварын дагуу зөвхөн бичгээр, монгол хэлээр байгуулна.
- 9.9 Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор уг гэрээг түүний хавсралт болон бусад холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бүртгүүлэх ба уг гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр бүртгүүлнэ.
- 9.10 Харилцаа холбооны үйлчлэгч нь гэрээ байгуулахаас өмнө Зохицуулах хороонд хандаж, гэрээний төслийг хянуулах болон холбогдох заавар зөвлөмжийг авч болно.
- 9.11 Сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг хүлээн авах, холболт хийгдэх, гэрээ байгуулах үйл явц нь энэхүү нөхцөлийн Хавсралт 3-т заасан дарааллын дагуу явагдана.

#### АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1 Энэхүү нөхцөлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар Журмын 10.1 дэх хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлнэ.
- 10.2 Маргалдагч талууд Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг хүлээж авахыг эрмэлзэх бөгөөд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно.

### ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


| ИНТЕРФЕЙС           |                                                                                                                                                                                                                                                                           |
|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| IP (GE, FE) холболт | <ul style="list-style-type: none"> <li>• IEEE 802.1Q стандартыг хангасан байх.</li> <li>• Портын төрөл: <ul style="list-style-type: none"> <li>- Electrical UTP RJ45 cat6 straight cable</li> <li>- Optical single mode sm-1310-1.25G LC connector</li> </ul> </li> </ul> |
| STM-1 холболт       | <ul style="list-style-type: none"> <li>• ITU-T G.957 стандартыг хангасан байх</li> <li>• Оптик кабелийн төрөл: <ul style="list-style-type: none"> <li>- Single mode</li> <li>- Connector type LC</li> </ul> </li> </ul>                                                   |
| E1 холболт          | <ul style="list-style-type: none"> <li>• ITU-T G.703 стандартыг хангасан байх</li> </ul>                                                                                                                                                                                  |

| ДОХИОЛОЛ                          |                                                                                           |
|-----------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| Session Initiation Protocol (SIP) | <ul style="list-style-type: none"> <li>• ITU-T G.729 стандартыг хангасан байх.</li> </ul> |
| Signaling System 7 (SS7)          | <ul style="list-style-type: none"> <li>• ITU-T G.711 стандартыг хангасан байх.</li> </ul> |

### ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

|                                                                                                                                                                              |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Байршил 1:</b><br/>Скаймедиагийн төв байр, 2-р давхар, Техникийн өрөөний төхөөрөмжийн гаралт дээр байрлана. Бүх төрлийн холболт хийх боломжтой.</p>                    |
| <p><b>Байршил 2:</b><br/>Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн төв байр, 2-р давхар, Техникийн өрөөний төхөөрөмжийн гаралт дээр байрлана. IP болон E1 холболт хийх боломжтой.</p> |
| <p><b>Байршил 3:</b><br/>Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн төв байр, В1 давхар, Шахтын өрөөнд FDF дээр байрлана. Шилэн кабелийн шөрмөсөөр холболт хийх боломжтой.</p>         |





## СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

### СКАЙМЕДИА КОРПОРАЦИ ХХК БОЛОН .....ХХК-ИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

202..... оны ..... дугаар сарын .....-ны өдөр      № .....      Улаанбаатар хот

Сүлжээ хоорондын харилцан холболтын энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Монгол Улсын Харилцаа холбооны тухай, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомж, Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос харилцан холболтын талаар баталсан журмуудыг үндэслэн:

Нэг талаас: Скаймедиа корпораци ХХК (цаашид “Скаймедиа корпораци” гэх), түүнийг төлөөлж Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д заасныг үндэслэн Гүйцэтгэх захирал .....,

Нөгөө талаас: ..... ХХК (цаашид “.....” гэх), түүнийг төлөөлж Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д заасныг үндэслэн Гүйцэтгэх захирал ..... (цаашид хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

#### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Талууд өөрийн сүлжээний хэрэглэгчдийн хэрэгцээг хангах зорилгоор нөгөө талын сүлжээтэй харилцан холболт хийх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.
- 1.2 Талууд харилцан холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.3 Талууд ХХЗХ-ноос баталж гаргасан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.4 Гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:
  - 1.4.1 Үндсэн хэсэг:
    - 1.4.1.1 Ерөнхий зүйл;
    - 1.4.1.2 Талуудын эрх, үүрэг;
    - 1.4.1.3 Техникийн нөхцөл;
    - 1.4.1.4 Ашиглалт үйлчилгээ;
    - 1.4.1.5 Төлбөр тооцоо;
    - 1.4.1.6 Нууц хадгалах;
    - 1.4.1.7 Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх;
    - 1.4.1.8 Хариуцлага;
    - 1.4.1.9 Маргаан шийдвэрлэх;
    - 1.4.1.10 Гэрээний үйлчлэх хугацаа;
    - 1.4.1.11 Давагдашгүй хүчин зүйл;
    - 1.4.1.12 Бусад.
  - 1.4.2 Хавсралт 1. Харилцан холболт хийх техникийн үзүүлэлтүүд, зааглах цэгийн байршил;
  - 1.4.3 Хавсралт 2. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал;



- 1.4.4 Хавсралт 3. Талуудын сүлжээний дугаарлалт;
- 1.4.5 Хавсралт 4. Харилцан холболтын үйлчилгээний тариф;
- 1.4.6 Хавсралт 5. Мэдээлэл солилцох албан тушаалтан, тэдгээрийн нэрс, холбоо барих арга хэрэгсэл.
- 1.5 Гэрээний хүрээнд талууд доор дурдсан харилцан холболтын үйлчилгээг үзүүлнэ:
  - 1.5.1 Скаймедиа корпораци:
    - 1.5.1.1 Дотоод дуудлага хийх;
    - 1.5.1.2 Дотоод дуудлага хүлээн авах;
    - 1.5.1.3 Улс хоорондын дуудлага гаргах;
    - 1.5.1.4 Улс хоорондын дуудлага оруулах.
  - 1.5.2 .....:
    - 1.5.2.1 Дотоод дуудлага хийх;
    - 1.5.2.2 Дотоод дуудлага хүлээн авах;
    - 1.5.2.3 Улс хоорондын дуудлага гаргах;
    - 1.5.2.4 Улс хоорондын дуудлага оруулах.

### **Хоёр. Талуудын эрх, үүрэг**

- 2.1 Талууд доор дурдсан эрхийг эдэлнэ:
  - 2.1.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсвэл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;
  - 2.1.2 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах, гэрээнээс татгалзах, цуцлах, дуусгавар болгох тухай санал гаргах;
  - 2.1.3 Нөгөө тал буруутай нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
  - 2.1.4 Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд 8 дугаар зүйлд заасан хариуцлагын механизмыг хэрэглэх;
  - 2.1.5 Үйлчилгээний төлбөр, алданги нэхэмжлэн авах;
  - 2.1.6 Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах;
  - 2.1.7 Шаардлагатай нөхцөлд холбогдох баримтуудыг гаргуулан авах;
  - 2.1.8 Гэрээний хэрэгжилтэд харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах.
- 2.2 Талууд доор дурдсан үүргийг хүлээнэ:
  - 2.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
  - 2.2.2 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлөх;
  - 2.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талынхаа бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
  - 2.2.4 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг тогтоосон хугацаанд нь нөхөн төлөх;
  - 2.2.5 Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх;
  - 2.2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх бол ХХЗХ-нд 72 цагийн өмнө, өөрийн сүлжээний болон гэрээнд оролцогч талын хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;
  - 2.2.7 ХХЗХ болон салбарын эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, нөхцөл шаардлага, тогтоол шийдвэрийг чанд мөрдөж ажиллах.

### **Гурав. Техникийн нөхцөл**

- 3.1 Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт
  - 3.1.1 Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл, марк, интерфэйсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж,



- багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байх ба өөрчлөлтүүдийг тухай бүр тусгана.
- 3.1.2 Сүлжээ хоорондын дохиолол нь CCS7 байх ба цаашид өргөн зурвасын дохиоллын бусад протокол ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.3 Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь  $10^{-11}$  байна.
- 3.2 Зааглах цэг
- 3.2.1 Сүлжээний зааглах цэгийн байршил Хавсралт 1-д заасны дагуу байна.
- 3.2.2 Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
- 3.2.3 Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 3.2.4 Талууд зааглах цэгээс хоёр тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.
- 3.3 Сүлжээний ачаалал
- 3.3.1 Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
- 3.3.2 Нэгж шугамд ноогдох ачааллын хэмжээг 0.65 Эрлангаас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.3.3 Талуудын сүлжээнд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг гурван сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.4 Дугаарлалт
- 3.4.1 Талуудын сүлжээний дугаарлалт нь ХХЗХ-ноос олгогдсон дугаарлалтын хүрээнд Хавсралт 3-т заасны дагуу байна.
- 3.4.2 Аль нэг тал хууль тогтоомжийн хүрээнд сүлжээний дугаарлалт шинээр үүсгэх тохиолдолд талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж баталснаас хойш ажлын таван өдөрт багтаан нөгөө тал сүлжээндээ үүсгэнэ.
- 3.4.3 Талууд нөгөө талын сүлжээнд яриа төгсгөхдөө дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулах үүрэгтэй. Энэ нь улс хооронд болон дотоод ярианд ижил хамаарна.

#### Дөрөв. Ашиглалт үйлчилгээ

- 4.1 Зааглах цэгээс хоёр тийш талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл саатлын засвар, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.2 Талууд өөрийн сүлжээнд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд аль болох ачаалал багатай өдөр, цагийг сонгох ба ажиллах хугацаа, горимыг хуанлийн долоо хоногийн өмнө албан бичиг болон цахим шуудангийн аль алианаар нь урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 4.3 Талууд харилцан холболтын ярианы өгөгдлүүд нь талуудын төлбөр тооцооны системд зөв ажиллаж байгаа талаар жил бүрийн эхний улиралд багтаан тест хийн баталгаажуулж протокол үйлдэж байна.
- 4.4 Аль нэг тал нь нөгөө талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан тал нь шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах буюу нэн даруй нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлнө.
- 4.5 Талууд өөрсдийн сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Аль нэг талын буруутай үйлдэл, санамсар болгоомжгүй байдлаас, мөн техник технологи, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус гэмт хэргийн шинжтэй халдлага, дайралт (fraud, attack) зэрэгт өртөх тохиолдолд тухайн тал нь нөгөө талд учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 4.6 Талууд өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн



- улмаас харилцан холболт хийсэн болон холбогдсон тохиолдолд дээрх шаардлагыг хангаагүй тал нь үүссэн хохирлыг хариуцна.
- 4.7 Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг Хавсралт 5-д заасан байна.

#### **Тав. Төлбөр тооцоо**

- 5.1 Талууд 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан үйлчилгээнүүдийн харилцан холболтын төлбөрийг Хавсралт 4-т зааснаар сар бүр төлнө.
- 5.2 Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол үйлдэж сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээнд хавсаргана. Талууд нэгэнт холбогдсон, гэрээний хугацааг сунгах тохиолдолд энэхүү заалт хамаарахгүй.
- 5.3 Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцөлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг нэг секундийн алхамтайгаар тооцно.
- 5.4 Талуудын төлбөр тооцоо хариуцсан ажилтнууд харилцан холболт хийгдсэн ачааллын өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн зургаа хоногт багтаан электрон хэлбэрээр харилцан солилцож, хуанлийн найм хоногт багтаан тооцоог Хавсралт 4-т заасан тарифын дагуу цаасан дээр хийж баталгаажуулна.
- 5.5 Хэрэв талуудын ачааллын өгөгдлийн зөрүү нь аль бага талын өгөгдлийн  $\pm 1\%$ -иас хэтрээгүй бол талуудын өгөгдлийн дунджаар, аль бага талын өгөгдлийн  $\pm 1\%$ -иас хэтэрсэн нөхцөлд тухайн тайлант сарын тооцоог аль бага талын өгөгдлийн дүнгээр 5 дугаар зүйлийн 5.4-т заасан хугацаанд багтаан нийлж зөрүүг ажлын хэсэг байгуулан дараагийн тайлант сарын төлбөр тооцоо нийлэхээс өмнө тодорхойлж дараа сарын төлбөр тооцоонд тусгана.
- 5.6 Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог 5 дугаар зүйлийн 5.4-т заасан хугацаанаас хойш ажлын гурван өдөрт багтаан нийлж илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг хүргүүлэх ба хүлээн авсан нэхэмжлэхийн дагуу төлбөр хариуцагч тал нь тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 15 хоногийн дотор харилцан холболтын төлбөрийн зөрүүг түүнд ноогдох НӨАТ-ын хамт төлнө.
- 5.7 Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан түрүүлж өгнө.
- 5.8 Талууд харилцан холболтын ачааллын өгөгдлийн зөрүүг Хавсралт 4-т заасан үйлчилгээний чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 5.9 Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.10 Талуудын сүлжээнд төгсөж байгаа ачаалал нь Хавсралт 3-т дурдсанаас өөр дугаарлалтаар төгссөн тохиолдолд талуудын холбох шугамаар орж ирсэн бүх ачааллыг талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.
- 5.11 Талууд нь тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн таван хувийг тус тусын талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 5.12 Аль нэг тал өөрийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 өдрийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.13 Гэрээний 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу илүү төлөлттэй талдаа харилцан холболтын төлбөрийн нэхэмжлэхийг тухайн цаг хугацаанд гаргаагүй нь төлбөрийг шаардах эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

#### **Зургаа. Нууц хадгалах**

- 6.1 Талууд гэрээ байгуулах болон хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан нөгөө талын бизнесийн болон хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (дотоод зохион байгуулалт, техникийн шийдэл, хамгаалалт, аюулгүй байдал гэх мэт)-ыг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхол, эсвэл түүний эсрэг



- 6.2 Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд буруутай тал түүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.
- 6.3 Гагцхүү төрийн эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэл журмын дагуу шаардсанаар 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг олгож болно.
- 6.4 Талууд энэ гэрээний хүрээнд олж авсан нөгөө талын байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах үүрэг хүлээнэ.

#### **Долоо. Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх**

- 7.1 Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор хүссэн талд гаргаж өгнө. Талууд бусдаас авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 7.2 Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүрд нь аль болох шуурхай бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариу мэдэгдэнэ.
- 7.3 Талууд өөрийн сүлжээний дугаарлалтад өөрчлөлт оруулах, нөгөө талын сүлжээнд шинэ чиглэл үүсгүүлэх, чиглэл өөрчлүүлэх, хаах, холбох шугамын тоог нэмэх тухай асуудлыг нөгөө талдаа тухай бүр ажлын таван өдрийн өмнө мэдэгдэх ба хүлээж авсан тал ажлын цар хэмжээнээс хамааран гүйцэтгэх хугацааг тохирон хэрэгжүүлнэ. Жич: Тухайн дугаарын өөрчлөлт нь харилцан холболтын төлбөр тооцоотой холбоотой бол талууд энэ талаар харилцан тохиролцсоны дараа хэрэгжүүлнэ.
- 7.4 Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

#### **Найм. Хариуцлага**

- 8.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй байх эсхүл гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд **нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй.** Учирсан хохиролд бодит хохирлыг тооцно.
- 8.2 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах доор дурдсан аргыг шат дараатайгаар хэрэглэх эрхтэй байна. Үүнд:
  - 8.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлэх;
  - 8.2.2 Гэрээний 8 дугаар зүйлийн 8.3-т заасан нөхцөлийн дагуу алданги тооцох;
  - 8.2.3 Аль нэг тал нь харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас гурван сараар хэтрүүлсэн тохиолдолд 2 дугаар зүйлийн 2.2.6-р заалтыг хэрэгжүүлэн харилцан холболтын хязгаарлалт, салгалтыг хийх.
- 8.3 Алдангийг доор дурдсан нөхцөлд тооцно. Үүнд:
  - 8.3.1 Аль нэг тал 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн бол;
  - 8.3.2 Аль нэг талын аливаа алдаа эсвэл буруутай үйлдлээс шалтгаалж харилцан холболтын тооцоог 5 дугаар зүйлийн 5.4-т заасан хугацаанд багтаан нийлээгүйн улмаас 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу төлбөр төлөх хугацаа хойшилсон бол;
  - 8.3.3 Аль нэг тал энэ гэрээ болон хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцан холболтын тооцоог нийлээгүй, нийлэхийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас 5 дугаар зүйлийн 5.6-д заасан хугацаа өнгөрсөн бол.
- 8.4 Алданги нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.3 хувь байна.
- 8.5 **Аль нэг тал нь 8.2-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэж эхэлснээс хойш нөгөө тал хуанлийн 30 хоногийн дотор гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол аль нэг тал нь гэрээний 8.1-т заасан үндэслэлээр гэрээг дангаар цуцлах эрхтэй.**
- 8.6 Гэрээний 8 дугаар зүйлийн 8.2-т заасан арга хэмжээг хүлээсэн нь талуудыг гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхгүй байх болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх хууль зүйн үндэслэл болохгүй.



- 8.7 Учирсан хохирол гэдэгт аль нэг талаас гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талаас гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, гэм буруутай тал гэрээнд заасан үүргээ гүйцэтгэсэн бол нөгөө талд учрахгүй байсан зарлага зэрэг бодит хохирлыг тооцно.

#### **Ес. Маргаан шийдвэрлэх**

- 9.1 Гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 9.2 ХХЗХ-ноос гаргасан шийдвэрийг маргалдагч талууд аль болох хүлээж авна. Хэрэв ХХЗХ-ны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй эсвэл ХХЗХ хуульд заасан хугацаанд шалгаж хариу өгөөгүй бол талууд шүүхэд хандах эрхтэй.

#### **Арав. Гэрээний үйлчлэх хугацаа**

- 10.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар гэрээ 20..... оны ..... дугаар сарын .....-ны өдрөөс эхлэн ..... жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 10.2 Гэрээний хугацаа дуусахаас хуанлийн 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах, шинэчлэх санал гаргаагүй тохиолдолд гэрээ нь цаашид ижил нөхцөлөөр нэг жилийн хугацаагаар нэг удаа сунгагдана.
- 10.3 Талууд 8 дугаар зүйлийн 8.5-д зааснаас бусад тохиолдолд энэхүү гэрээг харилцан тохиролцож цуцалж болох ба гэрээнд заасан нөхцөлөөс бусад тохиолдолд гэрээг аль нэг тал дангаараа цуцлахыг хориглоно. Талуудын аль нэг нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ нөгөө талдаа хоёр сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 10.4 Гэрээний хугацаа дуусгавар болсноор мөн гэрээ цуцлагдсанаар гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой шаардах эрхээс бусад талуудад олгогдсон эрх, үүрэг мөн адил дуусгавар болно.

#### **Арван нэг. Давагдашгүй хүчин зүйл**

- 11.1 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 11.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурван өдрийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 11.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 11.4 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 11.5 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

#### **Арван хоёр. Бусад**

- 12.1 Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 12.2 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.



- 12.3 Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээг хавсралтуудын хамт ХХЗХ-нд хүргүүлнэ. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг ХХЗХ-нд тухай бүр хүргүүлж байна.
- 12.4 Талуудын хувь нийлүүлэгчид, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хувьцааны өмчлөл зэрэг өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран 10 дугаар зүйлийн 10.1, 10.2-т заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

**Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:**

**Скайтел ХХК:**

Улаанбаатар хот-14251, Сүхбаатар дүүрэг  
1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-9  
Скайтел плаза  
Бүртгэлийн гэрчилгээ: 9019001128  
Регистрийн дугаар: 2576376  
Утас: 91120202

**..... ХХК:**

Улаанбаатар хот-....., ..... дүүрэг  
.....-р хороо, ..... гудамж-.....  
.....  
Бүртгэлийн гэрчилгээ: .....  
Регистрийн дугаар: .....  
Утас: .....

**Гэрээ байгуулсан:**

*Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.*

**Скайтел ХХК-ийг төлөөлж:**

**..... ХХК-ийг төлөөлж:**

.....

.....

.....  
Гүйцэтгэх захирал

.....  
Гүйцэтгэх захирал



Скаймедиа корпораци ХХК, ..... ХХК-ийн  
Сүлжээ хоорондын харилцан холболтын  
..... тоот гэрээний  
Хавсралт 1

### ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Үзүүлэлт                                                   | Скаймедиа корпораци | ..... |
|------------------------------------------------------------|---------------------|-------|
| Холболтын байгууламжийн төрөл, марк                        |                     |       |
| Дамжуулах /нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк |                     |       |
| Холбох шугамын төрөл, марк, багтаамж                       |                     |       |
| Интерфейсийн төрөл                                         |                     |       |

### ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

| Зааглах цэг            | Байршил | Тайлбар |
|------------------------|---------|---------|
| Зааглах цэгийн байршил |         |         |
| Тоног төхөөрөмж        |         |         |

Хавсралт баталсан:

Скаймедиа корпораци ХХК-ийг  
төлөөлж:

.....

Гүйцэтгэх захирал

..... ХХК-ийг  
төлөөлж:

.....

Гүйцэтгэх захирал



**СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ**

Хавсралт баталсан:

**Скаймедиа корпораци ХХК-ийг  
төлөөлж:**

.....

Гүйцэтгэх захирал

..... ХХК-ийг  
**төлөөлж:**

.....

Гүйцэтгэх захирал



Скаймедиа корпораци ХХК, ..... ХХК-ийн  
 Сүлжээ хоорондын харилцан холболтын  
 ..... тоот гэрээний  
 Хавсралт 3

# ТАЛУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

## СКАЙМЕДИА КОРПОРАЦИЙН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

| Үйлчилгээ     |  | Дугаарлалт |
|---------------|--|------------|
| Суурин холбоо |  |            |

## ..... СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

| Үйлчилгээ |  | Дугаарлалт |
|-----------|--|------------|
| .....     |  |            |

Хавсралт баталсан:

Скаймедиа корпораци ХХК-ийг  
 төлөөлж:


.....

Гүйцэтгэх захирал

..... ХХК-ийг  
 төлөөлж:

.....

Гүйцэтгэх захирал



Скаймедиа корпораци ХХК, ..... ХХК-ийн  
 Сүлжээ хоорондын харилцан холболтын  
 ..... тоот гэрээний  
 Хавсралт 4

## ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

Дотоод ярианы харилцан холболтын үйлчилгээ

| Чиглэл |         | Хаанаас | Хаашаа | Тариф | Скаймедиа корпораци | ..... |
|--------|---------|---------|--------|-------|---------------------|-------|
| Эхлэл  | Төгсгөл |         |        |       |                     |       |
|        |         |         |        |       |                     |       |
|        |         |         |        |       |                     |       |

Улс хоорондын ярианы харилцан холболтын үйлчилгээ

| Чиглэл |         | Хаанаас | Хаашаа | Тариф | Скаймедиа корпораци | ..... |
|--------|---------|---------|--------|-------|---------------------|-------|
| Эхлэл  | Төгсгөл |         |        |       |                     |       |
|        |         |         |        |       |                     |       |
|        |         |         |        |       |                     |       |

Тайлбар: ..... Скаймедиа корпорацийн тухайн үйлчилгээний тариф  
 ..... тухайн үйлчилгээний тариф  
 ..... хэрэглэгч ..... улс хоорондын ярианы  
 урьдчилсан төлбөрт карт ашиглах тохиолдолд ..... нь  
 картаасаа орлогоо тооцож авна.

Хавсралт баталсан:

Скаймедиа корпораци ХХК-ийг  
 төлөөлж:

.....  
 .....  
 Гүйцэтгэх захирал

..... ХХК-ийг  
 төлөөлж:

.....  
 .....  
 Гүйцэтгэх захирал



**МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН НЭРС,  
ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ**

**Скаймедиа корпорацийн албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл**

| Ажлын<br>чиглэл                 | Алба, хэлтэс | Албан тушаал | Албан тушаалтны нэр,<br>холбоо барих хэрэгсэл |
|---------------------------------|--------------|--------------|-----------------------------------------------|
| Гэрээний<br>асуудлаар           |              |              |                                               |
| Техникийн<br>асуудлаар          |              |              |                                               |
| Төлбөр<br>тооцооны<br>асуудлаар |              |              |                                               |

..... албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл

| Ажлын<br>чиглэл                 | Алба, хэлтэс | Албан тушаал | Албан тушаалтны нэр,<br>холбоо барих хэрэгсэл |
|---------------------------------|--------------|--------------|-----------------------------------------------|
| Гэрээний<br>асуудлаар           |              |              |                                               |
| Техникийн<br>асуудлаар          |              |              |                                               |
| Төлбөр<br>тооцооны<br>асуудлаар |              |              |                                               |

**СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ,  
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ**

| № | Үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Баримтын нэр,<br>хэрэгжих хугацаа                                 |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| 1 | Хүсэлт гаргагч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтээ Скаймедиад ирүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                               | Албан бичиг                                                       |
| 2 | Хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг албан бичигт хавсаргана. Үүнд:<br>- Компанийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар<br>- Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар<br>- Зохицуулах хороотой байгуулсан дугаарлалтын гэрээ, холбогдох шийдвэр<br>- Холболтын байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холболт хийх санал, хамтран ажиллах ажилтнуудын утасны дугаар, цахим хаяг | Албан бичгийн<br>Хавсралт                                         |
| 3 | Скаймедиа нь хүлээж авсан баримт бичгийн иж бүрдэл бүрэн эсэх, хүчинтэй хугацаа зэргийг хянаж, шалгах.                                                                                                                                                                                                                                                                                            | Хүсэлт хүлээн авснаас<br>хойш ажлын 5 өдөр                        |
| 4 | Баримт бичгийн иж бүрдэл дутуу, холбогдох мэдээлэл дутуу бол энэ тухай мэдээллийг хүсэлт гаргагчид мэдэгдэх.                                                                                                                                                                                                                                                                                      | Албан бичиг<br>Хүсэлт хүлээн авснаас<br>хойш ажлын 5 өдөр         |
| 5 | Баримт бичгийн иж бүрдэл, холбогдох мэдээлэл бүрэн бол техникийн боломж, гэрээний нөхцөлийг хангаж байгаа эсэхийг судалж хариуг хүсэлт гаргагчид мэдэгдэх:<br>- Техникийн нөхцөл гаргах боломжтой бол энэ тухай мэдэгдэж, гэрээ байгуулах үйл ажиллагааг эхлүүлэх.<br>- Техникийн нөхцөл гаргах боломжгүй бол тухайн нөхцөлийг бүрдүүлэх боломжтой хугацааг дурдсан тайлбарыг хүргүүлэх.          | Албан бичиг<br>Хүсэлт хүлээн авснаас<br>хойш ажлын 10 өдөр        |
| 6 | Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний төслийг Скаймедиа талаас бэлтгэн хүсэлт гаргагчийн ирүүлсэн цахим хаягаар илгээх.                                                                                                                                                                                                                                                                   | Цахим шуудан<br>Хүсэлт хүлээн авснаас<br>хойш ажлын 15 өдөр       |
| 7 | Талууд гэрээний нөхцөлийн талаар санал солилцох, харилцан тохиролцох ажлыг хэрэгжүүлж гэрээний төслийг эцэслэн тохирох.                                                                                                                                                                                                                                                                           | Цахим шуудан<br>Гэрээний төсөл солилцсоноос<br>хойш ажлын 10 өдөр |
| 8 | Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулах.                                                                                                                                                                                                                                                                                                               | Бичгээр, монгол хэлээр<br>байгуулсан гэрээ                        |
| 9 | Гарын үсэг зурж баталгаажсан гэрээний нэг хувийг хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд хүргүүлж бүртгүүлэх.                                                                                                                                                                                                                                                                  | Гэрээнд гарын үсэг зурснаас<br>хойш ажлын 10 өдрийн дотор         |